

**Дундговь аймгийн “Хүн амын өсөлтийг хангах”
бодлого батлах тухай**

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.4 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Дундговь аймгийн “Хүн амын өсөлтийг хангах бодлого” –ыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Бодлого хэрэгжүүлэх төлөвлөгөөг жил бүр аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулахыг Хууль зүйн хэлтэс /Б.Түвшинбаяр, Нийгмийн хөгжлийн хэлтэс /Д.Дулмаа/, Санхүү, төрийн сангийн хэлтэс /А.Ганбат/-д тус тус үүрэг болгосугай.

Гурав. Хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд хяналт тавьж, үр дүнг 2 жил дутамд аймгийн Иргэдийн хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж байхыг аймгийн Засаг дарга / Ш.Төрбат/-д даалгасугай.

ДАРГА

Ц.МӨНГӨНЦООЖ

ДУНДГОВЬ АЙМГИЙН “ХҮН АМЫН ӨСӨЛТИЙГ ХАНГАХ” БОДЛОГО

/ 2009 - 2015 он /

Нэг. Нийтлэг үндэслэл

Аймгийн хүн амын шилжилт хөдөлгөөний сүүлийн 3 жилийн дүнгээс харахад 5226 хүн өөр аймаг, суманд шилжсэн. Шилжин явсан иргэдээс 41 хувь нь ажлын байраар хангагдаж, 14.7 хувь нь ар гэрээ дагаж, ажил хайхаар 12.3 хувь, зах зээлд ойртохоор 12 хувь, малчид 7.7хувь, суралцахаар 5.7 хувь, үр хүүхдээ дагаж 3.9 хувь, эмчлүүлэхээр 2.7 хувь нь тус тус шилжсэн байна.

Шилжих хөдөлгөөний урсгалыг авч үзвэл шилжих хөдөлгөөнд оролцсон иргэдийн 3694 нь буюу 70.6 хувь нь Улаанбаатар хот, 453 буюу 8.6 хувь нь Говьсүмбэр аймаг, 340 буюу 6.5 хувь нь Төв аймаг, үлдсэн хувь нь бусад аймаг, хотод шилжсэн байна. Үүнээс харахад Улаанбаатар хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөн нийт шилжигсдийн 70-аас дээш хувийг эзэлж байгаа нь ажил хөдөлмөр эрхлэх, амьжиргаагаа дээшлүүлэх, үр хүүхдээ суралцуулах, зах зээлд ойртож амьдрах, эрүүл мэнд боловсролын илүү чанартай үйлчилгээгээр хангагдах боломж хайх зэрэг шалтгаанаар шилжжээ.

Хүн амын шилжих хөдөлгөөн жил жилээс нэмэгдсэнээр олон тулгамдсан, бэрхшээлтэй асуудлууд бий болж байгаа тул шилжилт хөдөлгөөнд оролцогчдын бүртгэлийг сайжруулах, нийгмийн үйлчилгээнээс хүртэх хүртээмжийг нэмэгдүүлж, тэднийг орон нутагтаа тогтвор суурьшилтай ажиллаж амьдруулах шаардлагатай байна.

Монгол улсын Мянганы хөгжлийн тэргүүлэх 9 зорилтын хүрээнд багтсан хүн амын төвлөрөл, шилжилт хөдөлгөөнтэй холбогдон гарч буй сөрөг үзэгдлийг багасгах, шилжин суурьшигчдыг нийгмийн суурь үйлчилгээнд хамруулах зорилт, Иргэний баримт бичгийн үзлэг явуулах тухай Монгол улсын Засгийн газрын 2007 оны 129 дүгээр тогтоол, Хүн амын өрхийн болон хаягийн бүртгэлийг улсын хэмжээнд зохион байгуулж явуулах тухай Монгол улсын Засгийн газрын 2008 оны 5-р тогтоол, 2008 онд аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан аймгийн шилжилт хөдөлгөөнийг зохицуулах журмыг орон нутагт хэрэгжүүлэх, хүн амын шилжилт хөдөлгөөнийг зохицуулахад бүх шатны төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжийн оролцоог нэмэгдүүлэх, аймгийн дэд бүтцийн асуудлыг бүрэн шийдвэрлэж, иргэдээ ажлын байраар ханган өрхийн орлогыг нь нэмэгдүүлэх, тэдний нийгмийн баталгааг нь хангаж, эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцлийг бүрдүүлэх үүднээс Дундговь аймгийн “Хүн амын өсөлтийг хангах бодлого” боловсруулах зайлшгүй шаардлагатай байна.

Шилжилт хөдөлгөөнд нөлөөлж байгаа хүчин зүйлс

1. Зам харилцаа, барилга байгууламж хангалттай хөгжөөгүй, улсын нийслэл болон бусад суурин газруудтай шороон замаар холбогдсон
2. Сүүлийн жилүүдэд ган, зуд үргэлжилж бэлчээрийн даац хомсдсон бөгөөд элсний нүүдэл, цөлжилт нэмэгдсэн
3. Хүн малын ундны усны нөөц хомс, хатуулаг ихтэй тул хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэг
4. Эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний чанар хүртээмж сул
5. Ажлын байр хангалттай биш, томоохон үйлдвэрлэл үйлчилгээ хөгжөөгүй
6. Боловсон хүчний тогтвор суурьшил муу, тэдний ажиллах орчин бүрдээгүй гэх мэт

Хоёр. Дундговь аймгийн хүн амын өсөлтийг хангах бодлогын зорилго, тэргүүлэх чиглэл, хугацаа, санхүүжилт, үр дүн

Дундговь аймгийн хүн амын өсөлтийг хангах бодлогын зорилго нь хүн амын шилжилт хөдөлгөөнийг сааруулан, тэдний ажиллаж амьдрах нийгмийн баталгааг хангах замаар аймгийн нийт хүн амын тоог өсгөхөд оршино.

Энэхүү бодлогын үндсэн агуулга нь орон нутгийн дэд бүтцийг хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэн иргэдийг эрүүл мэнд, боловсролын чанартай үйлчилгээнээс тэгш хүртээмжтэй хүртэх боломж нөхцлийг бүрдүүлж, улмаар иргэдийг тогтвор суурьшилтай ажиллаж амьдруулахад чиглэгдэнэ.

Аймгийн хүн амын өсөлтийг хангах бодлогын тэргүүлэх чиглэлийг дараах байдлаар тодорхойлж байна.

- ✓ Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, байгаль орчны тогтвортой байдлыг хангах замаар иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлнэ.
- ✓ Дэд бүтцийн салбарыг хөгжүүлж, нэн түрүүнд шаардлагатай жижиг, дунд үйлдвэрлэл, уул урхайн салбарыг түлхүү хөгжүүлнэ
- ✓ “Эрүүл биед саруул ухаан” гэсэн зарчмыг баримтлан эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөг дээшлүүлнэ.
- ✓ “Чанартай боловсрол – Амьдралын баталгаа” болсон боловсролыг тэргүүлэх салбарын хэмжээнд хүртэл хөгжүүлнэ.

Хүн амын өсөлтийг хангах бодлогыг 2009 – 2015 он хүртэл хэрэгжүүлэх бөгөөд

1. Улс, орон нутгийн төсвөөс олгох хөрөнгө
2. Аймгийн Засаг даргын нөөц сан
3. Олон улсын байгууллагуудын тусламж, хандив
4. Иргэдийн оролцоогоор хуримтлагдсан тусламж, хандивын хөрөнгө
5. Бусад эх үүсвэрээс бүрдүүлнэ.

| № | Нэр | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 |
|---|---|-------|-------|-------|-------|-------|-------|--------------|
| 1 | Төрөлт /+/ | 2.12 | 2.11 | 2.16 | 2.19 | 2.17 | 2.2 | 2.19 |
| 2 | Нас баралт /-/ | 0.46 | 0.47 | 0.48 | 0.49 | 0.51 | 0.52 | 0.52 |
| 3 | Шилжин явагсад /-/ | 3.5 | 2.7 | 2.2 | 1.6 | 1.4 | 1.3 | 1.1 |
| 4 | Шилжин ирэгсэд /+/ | 0.5 | 1.8 | 3.2 | 3.2 | 1.9 | 1.6 | 1.4 |
| | Хүн амын тоо /2008 оны эцсийн байдлаар 47959 хүн/ | 47259 | 47209 | 48459 | 50039 | 51139 | 52189 | 53259 |

Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, байгаль орчны тогтвортой байдлыг хангах талаар

Өнөөгийн байдлаар

Шилжилт хөдөлгөөний судалгаанаас харахад 2005 - 2008 оны 10 сар хүртэл нийт 7083 хүн шилжсэнээс очих газраа ажлын байртай, зах зээлд ойртох, ажлын байр хайсан шалтгаанаар шилжигсэд 48.2 хувь, насны ангиллаар авч үзэхэд 20-39 хүртэлх настай хөдөлмөрийн насны иргэд 58.0 хувийг тус тус эзэлж байгаа нь ажлын байр дутагдалтай байгааг харуулж байна. Манай аймагт хүн амын орлогын түвшин доогуур, иргэдийн худалдан авах чадвар сул, хувийн хэвшлийн байгууллагуудад ажиллагсдын цалин хангамж бага, ажиллагсдын ур чадвар доогуур байна. Иймд хүн амын тогтвор суурьшилтай байх нөхцлийг хангахад ажлын байр олноор бий болгох асуудал чухал байна.

Сүүлийн 4 жилд “Өрх бүр үйлдвэрлэгч үйлчлэгч хөдөлгөөн” өрнүүлэн ажлын байр олноор бий болж, шинэ үйлдвэрлэл үйлчилгээнүүд нэмэгдсэн нь орон нутагт үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэн ажлын байр олноор гаргах боломж байгааг харуулж байна. Нэгэнт бий болсон ажлын байрыг тогтвортой хадгалж, зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх нь зайлшгүй шаардлагатай.

Шилжилт хөдөлгөөнд оролцож байгаа иргэдийн нэлээдгүй хэсэг нь малчид байгаа. Сүүлийн 10 шахам жил үргэлжилж байгаа ган зуд, цөлжилт нь малчдын амьдрал ахуй доройтох, ажилгүйдэл, ядуурал ихсэхэд нөлөөлж байна. Цөлжилт, элсний нүүдэл, хөрсний эвдэрлийг сааруулж, ургамалын төрөл зүйлийг хамгаалах зорилгоор нийт 173 өрх, 385.4 га бэлчээрийг хашсан байна.

Ургамлын гарц болон төрөл зүйлийн өөрчлөлтөөс шалтгаалан бэлчээрийн даац 20.8 хувиар хэтэрч, аймгийн нийт малчдын 30-аад хувь нь өөр аймгийн нутагт 3-5 жилийн турш отор нүүдэл хийж, тухайн нутаг орондоо суурьших хандлага ажиглагдаж байна.

Засгийн газрын тогтоолоор батлагдсан “Цөлжилттэй тэмцэх” болон “Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөрийн дагуу аймгийн дэд хөтөлбөрийг батлан хэрэгжүүлснээр 6 сумын 45 га талбайд ойжуулалт хийгдсэнээс гадна, жил бүр сум, байгууллага, аж ахуй нэгж бүр орчноо тохижуулах, мод зүлэг тарих хөдөлгөөн өрнүүлж, аймаг, сумын төвд нийт 25 га-д

40000 гаруй мод тарьж ургуулсан байна. Энэ нь манай нөхцөлд усалгаатайгаар мод тарьж, зурвас ойжуулалт хийх боломжтойг харуулж байна.

ЗОРИЛГО:1 Иргэдийн хөдөлмөрлөх эрхийг хамгаалах, бүтээмж, ур чадварыг хөгжүүлэх үндсэн дээр ажлын байраар ханган орлогыг нь нэмэгдүүлж, бизнесийн орчин, ажлын байрны тогтвортой байдлыг хангана.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 1.1 Хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг өрх бүрийн хэрэгцээтэй уялдуулж, өрхийн нэгээс доошгүй хүнийг ажилтай болгох замаар жилд 500-гаас доошгүй хүнийг ажилтай болгох
 - 1.2 Бүх салбарт ажиллаж байгаа ажилтан, ажилчдыг зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн сургаж бэлтгэх, ур чадварыг нь нэмэгдүүлэх, дадлагажуулах
 - 1.3 Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд уул уурхай, зам тээврийн ангийг шинээр нээж, говийн бүсийн аймгуудын шаардлагатай мэргэжилтэнг бэлтгэн, ойжуулалт, цэцэрлэгжүүлэлт, хүнсний ногооны ангийг туршилтын талбай, хүлэмжтэй болгож, дадлагын газруудыг түшиглэн үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах
 - 1.4 Мэргэжил олгох сургалтын нэр төрлийг олшруулан түүнд багшлах боловсон хүчнийг сургаж чадваржуулах
 - 1.5 Ажилгүй болон ажилгүйдэлд өртөж болзошгүй нийгмийн эмзэг бүлгийн иргэдийг мэргэжил эзэмшүүлэх болон давтан сургалтанд хамруулан ажлын байртай болгон ажил үйлчилгээ эрхлэх ажлын дадлага туршлага эзэмшүүлэн, хөгжлийн зээл тусламжинд хамруулах зэргээр амьжиргааны эх үүсвэртэй болгох, орлогоо нэмэгдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх
 - 1.6 Эрдэнэдалай, Говь-Угтаал сумдын хөдөлмөр эрхлэлтийн боловсролын төв, аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтсийн дэргэдэх Сургалт үйлчилгээний төвийг сургалт явуулах техникийн боломж, чадавхи хүртээмжийг нь дээшлүүлэх
 - 1.7 Жижиг дунд үйлдвэрлэлийн тухай хуулийг хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээний хүрээнд төрөлжсөн “Бизнес инкубатор”-ыг байгуулан ажиллуулж, жижиг зээл, ажлын байран дахь болон шавь сургалтыг өргөтгөх замаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих
 - 1.8 Албан бус секторыг албан ёсны хүрээнд оруулахад чиглэсэн санхүү, татвар, мөнгө зээл, бүртгэл, нийгмийн болон эрүүл мэндийн даатгал зэрэг арга хэрэгслийг ашиглан албан бус секторын хүрээг багасгах
 - 1.9 Ажлын байр шинээр бий болгосон аж ахуй нэгж байгууллагад эдийн засгийн урамшуулал олгох
 - 1.10 Аймгийн хэмжээнд хөдөлмөр зарцуулалт ихтэй нийтийг хамарсан бүтээлч ажлууд зохион байгуулж олон хүнийг ажлын байраар хангах, олгогдож байгаа ажлын хөлснөөс аливаа татвар төлөөс төлүүлэхгүй байх
-

- 1.11 Хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл, хөдөлмөр зуучлалын үйлчилгээг чанаржуулах, сумдыг энэ үйлчилгээнд өргөнөөр хамруулах
- 1.12 Малчдын хөдөлмөр зохион байгуулалтыг боловсронгуй болгох, аж ахуйгаа тогтвортой эрхлэх өргөжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх
- 1.13 Нийгмийн салбарын ажилтнуудын мэргэшлийн түвшинг дээшлүүлэн, нийгмийн ажилд хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудыг татан оролцуулах
- 1.14 Аймгийн нийт өрх, хүн амын амьжиргааг тогтоох ажлыг мэргэжлийн байгууллагын туслалцаатайгаар зохион байгуулж, ядуурлын зураглал гарган нийгмийн хамгааллын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сантай болгох
- 1.15 Стратегийн орд газруудаас иргэн бүрт 1.5 сая төгрөгтэй тэнцэх хэмжээний орлого хүртээх ажлыг эрх зүйн орчны дагуу зохион байгуулах.
- 1.16 Шинээр гэр бүл бологсад, нийт болон шинэ төрсөн хүүхдэд мөнгөн тусламж тэтгэмж, шинээр 3 дахь хүүхдээ төрүүлсэн гэр бүлд 300.0 төгрөг нэг удаа, эхийн алдар хоёрдугаар зэргийн одонтой эхэд 500.0 төгрөг, нэгдүгээр зэргийн одонтой эхэд 1.0 сая төгрөгний тэтгэмж олгох зэрэг нийгмийн хамгааллын арга хэмжээнд бүрэн хамруулахаас гадна орон нутгийн онцлогт тохируулан төрөлтийг дэмжих арга хэмжээ авах
- 1.17 Хүн амын тодорхой бүлгийн онцлог хэрэгцээнд тохирсон урьдчилан сэргийлэх, хөгжүүлэх, хамгаалах, зуучлах нийгмийн үйлчилгээг өргөжүүлэх зорилгоор сум бүрт “Нийгмийн үйлчилгээний төв” байгуулах
- 1.18 Бага орлоготой эмзэг бүлгийн иргэдийг үнийн өсөлтөөс хамгаалах бодлого явуулж тэдэнд хүнсний болон зайлшгүй шаардлагатай бусад зүйлийн дэмжлэг үзүүлэх
- 1.19 Өрхийн хэрэгцээ чадавхи санаачлагыг дэмжин “Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэн өрхийн хөгжлийн төлөвлөгөөг өөрсдийнх нь оролцоотойгоор боловсруулан жилд 100-аас доошгүй ядуу айл өрхийн амьжиргааг дээшлүүлэн түүний тогтвортой байдлыг хангах арга хэмжээ авах
- 1.20 Сайнцагаан суманд амьдарч байгаа хүнд хэлбэрийн өвчтэй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн “Халамжийн бүлэг” байгуулан ажиллуулах
- 1.21 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор ажил үйлчилгээ явуулах ажлын байртай болгох

Хүрэх үр дүн:

Орон нутагт ажлын байр олноор бий болж иргэдийн амьдралын чанар, орлогын түвшин дээшилж, ажилгүйдлийн түвшин 1.9-д хүрч буурна.

ЗОРИЛГО:2 Байгаль орчны даац, цаг уурын өөрчлөлтөд нийцүүлэн, нөөц баялгаа шавхалгүйгээр байгаль дэлхийгээ унаган төрхөөр нь хойч үедээ өвлүүлэн үлдээнэ.

[Type text]

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 2.1 Цөлжилтийг сааруулах, мал аж ахуйн бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малчдын ундны усны хэрэгцээг хангах болон худаг, усаа түшиглэж малын тэжээлийн ургамал, өрхийн хэрэгцээний төмс, хүнсний ногоо тариалах малчин өрхүүдийг дэмжих зорилгоор инженерийн хийцтэй худаг шинээр гаргах, худгуудыг сэргээн засварлах
 - 2.2 Аймгийн хэмжээнд усны хатуулаг, эрдэжилт өндөр байгаатай холбогдуулан иргэд, ялангуяа малчин өрхүүдийг ус цэнгэгжүүлэх, зөөлрүүлэх бага оврын тоног төхөөрөмжөөр хангах
 - 2.3 Олгойн говийн инженерийн байгууламжийн техник технологид бүрэн шинэчлэл хийх
 - 2.4 Онгийн голын усны нөөцийг хамгаалах, булаг, шандны нөөц багасах бохирдохоос хамгаалж мод, бут, сөөг тариалах арга хэмжээг өргөжүүлэх
 - 2.5 10, 15, 35 квт-ын шугамын дагуу бууруулах трансформатор суурилуулж, малчин өрхийг цахилгаанаар ханган, инженерийн хийцтэй худаг гарган зурвас ойжуулалт хийх, бэлчээр хашиж, жижиг бороожуулагчтай болгон хөрсний талхлалтыг багасгах
 - 2.6 Талхлагдсан болон талхлагдаж болзошгүй байгаа бэлчээрийг ашиглалтгүй өнжөөж, байгалийн аясаар нь сэргээх эдийн засаг, нийгмийн ач холбогдлыг малчдад ойлгуулж, тэдний хяналт, оролцоог нэмэгдүүлэх
 - 2.7 Нутаг усныхаа бэлчээрийг хамгаалах нөхөн сэргээхэд малчин бүрийн оролцоог тодорхойлж, модлог бутлаг ургамал тариулж хөрсний шилжилтийг зогсоох, бэлчээрт олон наст ургамал ургуулах арга ажиллаганд сургаж дадлагажуулах
 - 2.8 Тусгай хамгаалалттай газар, нутгийн сүлжээг өргөжүүлэн, удирдлагын тогтолцоо, хамгаалалтын менежментийг сайжруулах
 - 2.9 Малчдыг фермерийн аж ахуй эрхлэх талаарх ойлголт мэдлэгийг дээшлүүлж, хагас суурин аж ахуй эрхлэх боломжийг бүрдүүлэх
 - 2.10 Байгаль хамгаалагчийг шинээр томилж ажиллуулах, мөн идэвхтэн байгаль хамгаалагчийг ажлын үр дүнгээр нь урамшуулж ажлын бүтээмжийг сайжруулах
 - 2.11 Улсын тусгай хамгаалалттай газрын хэмжээг нэмэгдүүлэх
 - 2.12 Мод тарих, ногоон зурвас байгуулахад иргэд, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх
 - 2.13 Аймгийн төвийг 2015 он гэхэд бүрэн ойжуулах, ойжуулалт, цэцэрлэгжүүлэлтийн ажилд олон нийтийг татан оролцуулж, хөрсний эвдрэл, элсний нүүлтийг сааруулах
 - 2.14 Малчдыг модлог, бутлаг ургамлын ёроолд хунгарласан элсийг сийрүүлэх зориулалтын багажаар хангах
 - 2.15 Хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрүүдийг байгуулах
 - 2.16 Мандалговь хотын өнөөгийн хог хаягдлын цэгийг булж устгах. Шингэрүүлсэн шатдаг хий, шахмал түлш, брикетийн үйлдвэрлэл, хэрэглээг нэмэгдүүлэх зэрэг цогц арга хэмжээ авах
-

- 2.17 Сум бүрт хог, хаягдлын төвлөрсөн цэгийн хогийг шууж хөрсийг эрүүлжүүлэх, шинээр нэмэгдүүлэхгүй байлгах зорилгоор бага оврын зөөврийн болон түрдэг тракторын хөрөнгийг шийдвэрлүүлэх
- 2.18** Байгальд удаан хугацаагаар хадгалагддаг гялгар уут, нийлэг эдийн хэрэглээг бууруулах
- 2.19 Тэвш, Хөөтийн нүүрсний үйлдвэрийн техник, технологид шинэчлэл хийж, нүүрснээс шингэн түлш гаргаж авах нөхцлийг бүрдүүлэх
- 2.20 Эрээнд төмөр баяжуулах үйлдвэр, Хараат, Төмөртэйд төмөр-цайрын баяжуулах үйлдвэрүүдийг байгуулж, улмаар зүүн талын сумдыг уул уурхайн үйлдвэрлэлийн бүс болгон хөгжүүлэх

Хүрэх үр дүн:

Иргэд эрүүл аюулгүй орчинд ажиллаж, амьдрах орчин нөхцөл бүрдэж, малчид нүүдлийн мал ахуйгаас хагас суурин аж ахуйд шилжинэ.

Дэд бүтэц, үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх талаар

Өнөөгийн байдлаар

Улаанбаатар-Мандалговь чиглэлийн хатуу хучилттай замын ажлыг эхлүүлж, өндөр хурдны шилэн кабелд 3 сумыг холбож, бүх суманд үүрэн телефоны үйлчилгээ нээгдсэнээр, гар утас хэрэглэгчдийн тоог 9500 гаруйд хүрсэн.

Мандалговь хотод 6.25 км хатуу хучилттай зам тавьж байнгын ашиглалтад хүлээн авч, аймаг, сумын төвд 3-5 сувгийн телевизийн нэвтрүүлгийг үзэх боломжтой болсон.

Соёл амралтын цэцэрлэгт хүрээлэн, Их газрын чулуунд байгалийн задгай театр, Эрдэнэдалай, Дэлгэрцогт суманд спорт заал, Сайхан-Овоо суманд соёл спортын цогцолбор, Эрдэнэдалай, Баянжаргалан сумдад хүүхдийн цэцэрлэг, Говь-Угтаал суманд сум дундын эмнэлгийн барилга, багш, эмч, хуулийн ажилтны 8 айлын 3 сууц, Нийгмийн даатгалын хэлтэс, ХААН банкны байр зэрэг олон арван барилга баригдаж, 200 гаруй айл хувийн орон сууц барьж амьдрах орчин нөхцлөө сайжруулжээ.

Ард иргэдийнхээ амьжиргааны түвшинг дээшлүүлэх ядуурлыг бууруулах зорилгоор “Өрх бүр үйлдвэрлэгч- үйлчлэгч “хөдөлгөөнийг жил дараалан өрнүүлж амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрх, хүн амын болон ажилгүйдлийн судалгааг нарийвчлан гаргаж, барилгын материал, эсгий эсгий эдлэл, оёдол, г^р ахуйн модон болон төмөр эдлэл, талх нарийн боов, хүнсний ногоо тарих, ноос боловсруулах чиглэлээр нийт 265 бүлэгт иргэдийг хамруулан зохион байгуулж тэдний үйл ажиллагааг дэмжлээ.

Өнгөрсөн 4 жилд 3288 хүнийг байнгын, 3193 хүнийг түр ажлын байраар хангаж, ажилгүйдлийн түвшинг 2.5 хувьд хүргэж бууруулсан байна.

ЗОРИЛГО:3 Уул уурхай, ашигт малтмалын боловсруулах болон хөдөө аж ахуй, орон нутгийн түүхий эдэд тулгуурласан жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлж, зам тээвэр,

харилцаа холбоо, аялал жуулчлал, нийтийн аж ахуйн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 3.1 “Улаанбаатар-Мандалговь-Даланзадгад” чиглэлийн хатуу хучилттай авто замыг Дэлгэрцогт, Луус, Хулд сумдаар дамжуулан тавих
 - 3.2 “Улаанбаатар-Мандалговь-Тавантолгой-Оюутолгой”-н 220 кВ-ын 560 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барьж эрчим хүчний нэмэгдэл эх үүсвэр бий болгох
 - 3.3 Сумдад олон сувгийн нэвтрүүлэг хүлээн авах болон интернетээр харилцах боломжийг нэмэгдүүлэх
 - 3.4 Гар утас үүрэн телефоны олон сүлжээ нэвтрүүлж, бүх сумдыг шилэн кабельд холбон, нийт малчин өрхийн 90 хувийг гар утас үүрэн телефон хэрэглэх, улмаар 10 сувгийн телевизийн нэвтрүүлэг хүлээн авч үзэх боломж бүрдүүлэх
 - 3.5 Мандалговь хотын ундны болон үйлдвэрлэлийн зориулалттай усны хангалт, нөөцийг шинээр тогтоон, малчин өрхийг ус зөөлрүүлэх тоног төхөөрөмж ашиглаж сургах
 - 3.6 Бүх сумдын сургууль, эмнэлэг, цэцэрлэгийг цэвэр бохир ус, дулааны нэгдсэн систем, цэвэрлэх байгууламжтай болгох
 - 3.7 Аймгийн төв, сумдад орон сууцны барилгыг барьж бага, дунд орлоготой иргэдэд урт хугацаатай хөнгөлөлтэй зээл олгох бодлого баримтлан, орон сууцжуулах
 - 3.8 Хүрэн нүүрсийг шингэрүүлж, шатахуун гарган авах үйлдвэр байгуулж, бинзен үйлдвэрлэн дотоодынхоо хэрэгцээний тодорхой хувийг хангах
 - 3.9 Байгалийн баялаг, ашигт малтмалыг эдийн засгийн эргэлтэнд оруулж, зүүн талын сумдыг орон нутгийн түүхий эдэд түшиглэсэн уул уурхайн үйлдвэрлэлийн бүс болгон хөгжүүлэх
 - 3.10 Зэрэглэл өндөртэй зочид буудал, ресторан, жуулчны бааз байгуулах санаачлага гаргасан ААН-ийг дэмжих
 - 3.11 Орчин үеийн шаардлагад нийцсэн мал нядлах, мах боловсруулах болон хөлдөөж хадгалах жижиг үйлдвэр байгуулах
 - 3.12 Сум бүрт сүүний чиглэлээр үхэр, ямааны, тэмээ олонтой говийн сумдад ингэний фермерийн аж ахуйг байгуулах
 - 3.13 Хүлэмжийн болон төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалах санал санаачлагыг дэмжиж, сонгомол сортын үрийн нөөцтэй болж, худаг, булаг шанд түшиглэн төмс, хүнсний ногоо тариалж хүнсний хэрэгцээг бүрэн хангах
 - 3.14 Хулд сумын Олдох, Цагаан чулуутын орчмын усны нөөц, хөрсний судалгааг нарийвчлан хийж, 100-аас доошгүй га талбайд газар тариалан эрхлэх боломжийг судлах
-

3.15 Сум бүр гахай, тахиа, галууны зэрэг туслах аж ахуй хөгжүүлэх

Хүрэх үр дүн:

Харилцаа холбоо, дэд бүтэц хөгжиж, айл бүр өрхийн аж ахуй эрхлэх дадал хандлагатай болж, жижиг дунд үйлдвэрлэлүүд бий болно.

Хүн амын эрүүл мэндийг хамгаалах талаар

Өнөөгийн байдлаар

Монгол улсын Засгийн газрын 52 дугаар тогтоолоор батлагдсан “Нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний 3 дахь хөтөлбөрийн дагуу аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулан аймгийн Засаг даргын 303 тоот захирамжаар баталгаажуулан хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд эхийн эндэгдлийг бууруулах стратеги төлөвлөгөө, НҮЭМ-ийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Эхийн эрүүл мэнд нь нялхсын эндэгдэл, өвчлөлд шууд нөлөөлөх тул онцгой анхаарах асуудлын нэг билээ.

2002 онд төрөлт 19.3 промилль байсан бол 2007 онд 15.8 болж сүүлийн 4 жилд төрөлт эрс буурсан байна.

Мөн ядуурал ажилгүйдэл зэрэг улс орны нийгэм эдийн засагт гарч байгаа өөрчлөлтүүд эх хүүхдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна. Төрөөс хүүхдэд олгож байгаа мөнгөн тэтгэлгийн хөтөлбөр, эхийн халамжийн мөнгө нь зөвхөн ядуу болон эмзэг бүлгийн эхчүүдийн төрөлт ихсэх нэг хүчин зүйл болж байна.

Аймгийн хэмжээнд жирэмсэн эмэгтэйчүүдэд төрөхийн өмнө болон төрсний дараа амарч сувилах 16 амрах байр ажиллаж байгаа бөгөөд аймгийн төвийн болон сумдын эхчүүдийн амрах байранд 302 эх амарсан ба 2367 ор хоног ашигласан нь хангалтгүй үзүүлэлт байна.

Аймгийн хэмжээнд нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл хэдийгээр буурч байгаа ч сүүлийн жилүүдэд нярайн перинаталь эндэгдэл тогтвортой буурахгүй байна. Перинаталь эндэгдэл нь жирэмсэн эхийн эрүүл мэнд, төрөлтийн үеийн нөхцөл байдлууд, тухайлбал төрөх үеийн хүндрэл, эрүүл мэндийн мэргэжлийн ажилтан, нярайг эх барьсан эсэхээс ихээхэн шалтгаалдаг. Мөн нийгэм, эдийн засаг, байгаль орчин, хүмүүсийн амьжиргааны түвшин, ядуурал зэрэг хүчин зүйлтэй холбоотойгоор үүсэх өвчин эмгэгүүд нярайн хожуу үеийн нас баралтад нөлөөлж байна.

ЗОРИЛГО:4 Эх, нялхсын эрүүл мэндийг хамгаалах, эндэгдлийг бууруулах, нарийн мэргэжлийн эмч нарын нийгмийн баталгааг хангаж, тогтвор суурьшилтай ажиллуулах замаар хүн амын тогтвортой өсөлтийг хангана.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 4.1 Эмч, мэргэжилтнүүдийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, нярайн мэргэжлийн эмчийг төрөх, хүүхдийн тасаг тус бүрт ажиллуулах
- 4.2 Хүүхдийг 6 сар хүртэл нь эхийн сүүгээр дагнан хооллохын ач холбогдлыг иргэдэд ойлгуулах
- 4.3 Хүн амын эмзэг хэсэгт хамрагдах хүүхэд, жирэмсэн ба хөхүүл эхчүүдийг иоджуулсан давс, бичил бодисоор баяжуулсан гурил, хүнсний бүтээгдэхүүнээр хангах зохион байгуулалтын арга хэмжээ авах
- 4.4 Жирэмсэн эхийн эрүүл мэндийг сайжруулах, төрөх үеийн хүндрэлээс сэргийлэх
- 4.5 Амрах байрыг гэрийн нөхцөлд ойртуулах, үйлчилгээг 24 цагаар ажиллуулах, хоол, витаминий эмчилгээ болон бусад эмийн бус эмчилгээг өргөжүүлэх
- 4.6 Үргүйдлийг эмчлэх багаж тоног төхөөрөмж, эмч мэргэжилтэнийг сургаж бэлтгэх, үр хөндөлтийг заалттай болгох
- 4.7 ХДХВ/ДОХ, БЗДХ-тай тэмцэх сэргийлэх мэргэжлийн багийг эмчлэгч эмч, тархвар зүйч эмч, лаборант, эрүүл мэндийн боловсрол хариуцсан арга зүйч нарын бүрэлдэхүүнтэй байгуулан анхан шатны нэгжид хүрч ажиллуулах
- 4.8 Хөдөө орон нутагт олон жил тогтвор суурьшилтай ажиллаж байгаа эмч нарын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, орон байраар хангах арга хэмжээг үе шаттай шийдвэрлэх
- 4.9 Их, дээд сургууль төгсөөд орон нутагт 2-оос доошгүй жил ажилласан их эмч нарыг эхний ээлжинд нарийн мэргэжил эзэмшүүлэх, сургалт, дамжаанд хамруулах
- 4.10 Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэргэжлийн зэргийг ахиулж 70 хувьд хүргэн, магистар, докторантурт суралцахад дэмжлэг үзүүлэх

Хүрэх үр дүн:

Эх, хүүхдийн эндэгдэл буурч, нярай, эх барих эмэгтэйчүүдийн эмчийг дадлагажуулан сургаж, тэдний нийгмийн баталгааг хангаснаар орон нутагт тогтвор суурьшилтай ажиллана.

Боловсролыг тэргүүлэх салбарын хэмжээнд хүргэх талаар

Өнөөгийн байдлаар

2008-2009 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 18 сургууль үйл ажиллагаа явуулж байна. Эдгээрийн сургуулийн 326 бүлэгт 9237 хүүхэд суралцаж байна. Үүнээс 223 бүлэгт 6320 суралцагч нэгдүгээр ээлжинд, 103 бүлэгт 2917 суралцагч хоёрдугаар ээлжинд хичээллэж байгаа бөгөөд 865 удирдах ажилтан, багш, ажилчид ажиллаж байна. Тэдний 54.3 хувь буюу 470 нь үндсэн багш юм.

Бага боловсролын хамран сургалтын цэвэр жин сүүлийн жилүүдэд буурсан үзүүлэлттэй байгаа бөгөөд суурь боловсрол эзэмшигчдээс сургууль завсардагчид нь ажил эрхлэх, амьдралын боломжгүй гэсэн шалтгаантай байна.

Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байрны цэвэр бохир усны хангамж муу, угаалтуурын тоо цөөн, халуун усаар хангах нөхцөл бүрдээгүй байна.

Суралцагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зориулалтын байр, тоног төхөөрөмжгүйгээс хүүхдийн хүрэлцээнээс шалтгаалан сурч хөгжих орчин бүрдүүлэхэд хүндрэл бэрхшээл учирч байна.

ЗОРИЛГО:5 Суралцагчдад сурч, хөгжих таатай орчин бүрдүүлж, сургалтын чанар үр дүнг дээшлүүлэн, багшлах боловсон хүчнийг чадавхижуулан, шилдэг, тэргүүний боловсон хүчнээ урамшуулж ажиллана.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

Сурч хөгжих нөхцөл бүрдүүлэх

- 5.1. Багшийн мэргэжлийн ур чадварын өсөлтийг бодитой үнэлж, мэргэжлийн ур чадвар сайтай багшийг орон нутагтаа тогтвор суурьшилтай ажиллуулах тогтолцоо бүрдүүлж аймгийн шилдэг багшийн амжилтаа удаа дараалан хадгалсан багшийг урамшуулах журам гаргаж мөрдөх /Жил бүр 15 хүртэл багшийг шалгаруулж жилийн хугацаанд цалингийн 10 хувьтай тэнцэх урамшуулал сар бүр, 2 жил дараалан шалгарвал 15 хувь, 3-н жил дараалан шалгарвал 20 хувь, 5 жил шалгарсан багшид тэтгэвэрийн нас хүртэл сар бүр цалингийн 20 хувьтай тэнцэх мөнгөн урамшуулал олгох/
- 5.2.Багшийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд аймаг, сум, багийн Засаг дарга, боловсролын байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах
- 5.3.Боловсролын салбар дахь хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг бүх талаар дэмжин урамшуулах
- 5.4.Хүн амын сурах, амьдрах хэрэгцээнд тохирсон тасралтгүй боловсролын үйлчилгээ үзүүлэх
- 5.5.Иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн соёл урлагийн олон талт арга хэмжээнүүдийг хүн бүрт хүргэж, чанартай тогтмол зохион байгуулах
- 5.6.Соёл урлагийн салбарын ажилтнуудыг мэргэшүүлэх, мэргэжилтэй боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллаж, амьдрах орчин нөхцлийг бүрдүүлэх

Сургалтын чанар үр дүнг дээшлүүлэх

- 5.7.Олон улсын стандартад нийцсэн, орон нутгийн онцлогтой сургалтын хөтөлбөрүүдийг шинэчлэн боловсруулах.
- 5.8.Хөгжлийн бэрхшээлтэй сурагчдад боловсрол эзэмших тэгш боломж, сэтгэл зүйн болон материаллаг орчныг бүрдүүлэх, тэдэнтэй ажиллах багшийн мэргэжлийг дээшлүүлэх,чадваржуулах.
- 5.9.Сургууль цэцэрлэгийг мэргэжлийн багшаар бүрэн хангах.
- 5.10.Бүх сургуулиудыг стандарт хангасан спорт залтай болгож биеийн тамирын орчин үеийн техник хэрэгслээр иж бүрэн хангах.
- 5.11.Багш нарыг дотоод гадаадад мэргэжил дээшлүүлэх, туршлага судлуулах
- 5.12.Багшийг 3 жил тутам мэргэжил боловсролоо дээшлүүлэх боломж нөхцлөөр хангах.

[Type text]

5.13.ЕБС-иудыг интернэтийн сүлжээнд холбож, мэдээллийн технологийн хөгжлийг хангах, сургуулийг боловсрол соёлын төв болгох.

Материаллаг орчин нөхцлийг хангах

5.14.Зарим сургуульд хичээлийн болон шинээр дотуур байр барих, засварлан тохижуулах

5.15.Сургууль, цэцэрлэгийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, хичээлийн болон дотуур байрыг цэвэр бохир усны системд холбон, сурах амьдрах таатай нөхцлийг бүрдүүлэх

5.16.Сурагчдын дотуур байрыг цэвэр, бохир усны системтэй болгох, гал тогооны тоног төхөөрөмж, суралцагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зориулалтын байр, хэрэгслээр хангах арга хэмжээг дэс дараатай шийдвэрлэх

Хүрэх үр дүн: Олон улсын стандартад нийцсэн сургалтын хөтөлбөрүүдтэй болж, багш, сурагчдын ажиллах орчин нөхцөл сайжирч, тогтвор суурьшилтай ажиллах боломж бүрдэнэ.

